



# СОЁМБО МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№06 /219/ 2022.01.07

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

## ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалах эмгэг судлал, шүүх эмнэлгээс БХЯ, ЗХЖШ-ын УААХ, ЦДБЭЧ, Барилга захиалагчийн албаны цэргийн алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Батлан хамгаалах эрх зүйн тогтолцоо, цэргийн албаны сахилга хариуцлагын

хууль зүйн үндэслэл" сэдэвт сургалтыг Офицеруудын ордонд өнөөдөр зохион байгууллаа. Тус сургалтад Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооны хуульч Б.Бат-Ерөөлт, АШУИС-ийн багш Д.Энх-Өлзий нар илтгэл тавьж бие бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлэг өрнүүллээ.

Түүхэнд энэ өдөр

1914 он.

Өмнөд зүгийн цэргийн бүгд захирагч дарга, шалгарсан баатар, гүн Мурангаагийн захирсан цэргээс 100 цэргийг эргүүлэн татаж, Түшээт ханаймгийн Мэргэн жүн ван Цэсэнжавын хошууны өмнө захад суулгав.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧДЫН ЭСЭЭ ОЛОН УЛСЫН УРАЛДААНД ӨРСӨЛДӨНӨ



бичлэгийн уралдааны тэргүүн байрыг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн Соёл хүмүүжлийн дарга ахмад Ч.Нямсүрэн, дэд байрыг 014 дүгээр ангийн Эмнэлгийн алба, эрүүл мэндийн төвийн дарга дэслэгч Э.Буянжаргал, гуравдугаар байрыг 350 дугаар ангийн Салааны ахлагч, тасгийн захирагч ахлах ахлагч Э.Борил нар тус тус эзэлсэн бол 123 дугаар ангийн МББ-ны хангалт үйлчилгээний салааны хангалт үйлчилгээний тасгийн нярав, жолооч дэд ахлагч Ц.Отгонбаяр, 016 дугаар нэгтгэлийн Хуягт техникийн албаны нярав завсарчин дэд ахлагч Ж.Цэнгүүнбаяр нар тусгай байрт шалгарлаа.

Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан "Бидний мэргэжил-Миний бахархал" уралдааны шилдгүүдэд шагнал гардуулан өгсөн юм. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулагч албан тушаалтнуудад өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг чадвараа ахиулах сэдэл төрүүлэх, тэдний баримт бичиг боловсруулах, бичих, найруулах чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцуулах зорилготойгоор 10 сарын турш үргэлжилсэн тус уралдаанд 104 цэргийн алба хаагч оролцсон байна.

"Бидний мэргэжил-Миний бахархал" уралдааны тэргүүн байрт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн соёл хүмүүжлийн албаны дарга хошууч Д.Долгоржав, дэд байрт тус нэгтгэлийн соёл хүмүүжлийн зааварлагч дэслэгч Ц.Бадамсүрэн нар шалгарсан бол 256 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга хошууч Л.Амарбаясгалан удааллаа.

ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба уралдааны шилдгүүдэд баяр хүргэж хэлсэн үгэндээ "Эсэвгээр дамжуулж Зэвсэгт хүчиндээ хэрэгцээтэй, авууштай, бодуштай санаа бодлыг тусгасан байх. Шилдгүүдэд багтсан хоёр эмэгтэй цэргийн алба хаагчдаа хэлэхэд бусдыгаа манлайлж, үлгэрлэсэнд олзуурхаж байна. Та бүхэн авьяас чадвараа хөгжүүлж, зөвхөн уралдаан тэмцээнээр хязгаарлалгүй өөрсдийн бичсэн эсээ, нийтлэлээ "Соёмбо" сонин, "Цэргийн шинэчлэл" сэтгүүлд хэвлүүлж олон түмний хүртээл болгож байгаарай. "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн

газар"-ын хамт олонд, Зэвсэгт хүчний алба хаагчдыг дэмжиж ажиллан, урам өгсөнд талархаж байгаагаа илэрхийлээд ажлын өндөр амжилт хүсье" гэлээ.

Түүнчлэн "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар"-ын Залуучуудын хөгжлийн газрын дарга О.Сэлэнгэ "Өнгөрсөн онд Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой тохиосон. Энэ хүрээнд ЗХЖШ болон ХЗЦК-тай хамтран ажиллаж, олон ажлын ард гарсан. Цаашид "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар" та бүхэнтэй илүү өргөн хүрээнд хамтран ажиллана. Залуучуудын маань зарим төлөөлөл цэргийн алба хааж байна. Тэдгээр залууст гэр бүлийн боловсрол олгох, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байгаа. Чимээгүйхэн хөдөлмөрлөж, баатарлаг үйлсийг бүтээж байгаа та бүхнийг олон нийтэд сурталчлан таниулах нь их чухал. Энэ чиглэлээр бид гар нийлэн ажиллана гэдэгт итгэлтэй байна. Эсээ бичлэгийн уралдаанд шилдгээр шалгарсан та бүхнээр бахархаж байгаагаа хэлье. Ингээд Монгол Улсынхаа төлөө зүтгэж байгаа та бүхний ариун үйлсэд амжилт хүсье" хэмээв.

Мөн Залуучуудын байгууллагын 100 жилийн ойн медалиар Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга хошууч Л.Амарбаясгаланг шагналаа.

Төгсгөлд нь Залуучуудын хөгжлийн газрын дарга О.Сэлэнгэ шилдгээр шалгарсан дээрх бүтээлүүдийг олон улсын "Эр зоригийн түүх" эсээ бичлэгийн уралдаанд Монгол Улсаа төлөөлүүлэн оролцуулахаар болсон тухай баяртай мэдээ дуулгасан юм.

Мөн Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн медалиар төлөөлөл болгон Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга хошууч Л.Амарбаясгаланг шагналаа.

Төгсгөлд нь Залуучуудын хөгжлийн газрын дарга О.Сэлэнгэ шилдгээр шалгарсан дээрх бүтээлүүдийг олон улсын "Эр зоригийн түүх" эсээ бичлэгийн уралдаанд Монгол Улсаа төлөөлүүлэн оролцуулахаар болсон баяртай мэдээ дуулгалаа.



Цэргийн насны залууст зөв төлөвшил, зөв хандлага, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх зорилготой "MAX COURAGE" олон улсын хувь хүний хөгжлийн сургалтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-тай хамтарсан танхим болон цахим хосолсон хэлбэрээр өнгөрсөн оны 11 дүгээр сард зохион байгуулж явуулсан юм. Тус сургалтын төгсгөлд Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний дунд "Миний эр зориг" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зарласан билээ. Энэхүү уралдаанд Зэвсэгт хүчний 13 нэгтгэл, анги, байгууллагаас офицер, ахлагч, хугацаат

цэргийн алба хаагчдаас 95 эсээ ирүүлсэн бөгөөд шилдэг 9 эсээнээс "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар" шагналт байрын бүтээлүүдийг тодрууллаа.

Тэгвэл өчигдөр ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, АУГ-ын Суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэлзүйн хангалтын хэлтсийн дарга хурандаа Ц.Батсайхан, "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар"-ын Залуучуудын хөгжлийн газрын дарга О.Сэлэнгэ нар уралдааны шилдэг бүтээлүүдийн эздэд шагналыг нь гардуулав.

"Миний эр зориг" сэдэвт эсээ

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2.266.225 /69.7%/	2.164.363 /66.5%/	919.478 28,3%

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 7304 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 303	ЭДГЭРСЭН 6885
------------------------------	----------------------------	------------------

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 298,096,535
Эдгэрсэн Нийт: 256,753,221
Нас барсан Нийт: 5,481,668

2022.01.07 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 5/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:  
Эд, мал арвижна  
Наран ургах, шингэх:  
08.41-17.16  
Барилдлага: Түлэх  
Шүтэн барилдлага:  
Төрөн түгэхүй  
Суудал: Ус

Энэ өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дархны үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний хүч сайжирна.

Цахим шууданд

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 278 ДУГААР БАЙГУУЛАМЖИД АЖИЛЛАЛАА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн ахлагч тэргүүн ахлагч Н.Баттөмөр, Агаарын цэргийн командлалын хүний нөөцийн хэрэг хөтөлгөч ахлах ахлагч Х.Батхүлэг нар энэ сарын 2-3-

ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 278 дугаар байгууламжид ажиллалаа.

Ажлын хүрээнд ахлагчийн албан тушаалд энгийнээр томилогдон

ажиллаж байгаа бүрэлдэхүүнтэй явагдах цэргийн анхан шатны сургалтын бэлтгэл ажилтай танилцаж тус сургалтыг удирдан ажиллах ахлагч нарт үүрэг чиглэл өгч, суралцагчдад сурлагын өндөр амжилт хүслээ.

Мөн тэргүүн ахлагч Н.Баттөмөр тус байгууламжийн ахлагч нартай уулзаж Зэвсэгт хүчний ахлагчийн албаны өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл өгч, тэдний санал сэтгэгдлийг сонссон юм.

**АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ**

## МАРШИЙГ ХИЧЭЭЛИЙН ГУРВАН ЦЭГЭЭР ...



**Зэвсэгт хүчний 014 дүгээр анги**

2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу байнгын бие бүрэлдэхүүн, Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн

алба хаагчидтай тактик тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг хичээлийн гурван цэгээр төлөвлөн үйлдлээ. Ингэхдээ буудлагын цэгт офицерууд СБД-1, ахлагч нар БАД-2, ХЦАХ-чид БАД-1 боловсруулах, тактикийн

ажиллагаа болон хорлон сүйтгэх бүлгийн ажиллагаа, хордсон газар орныг туулах ажиллагаа зэрэг сургалтуудыг амжилттай зохион байгуулсан юм.

**Дэслэгч Р.БИЛЭГ**

## ЦАХИМААР УУЛЗАЖ АМАР МЭНДЭЭ ЭРЭВ



**Зэвсэгт хүчний 120 дугаар анги**

Энэ сарын 6-ны өдөр 2021 онд Баянгол дүүргээс хугацаат цэргийн албанд татагдан ирсэн алба хаагчдын шинэ жилийн үйл ажиллагааг нөхөж тэмдэглэлээ. Уг үйл ажиллагаанд Нийслэлийн БГД-ийн Засаг дарга Ө.Сумъяабаатар, ЗДТГ-ын дарга Б.Нарангэрэл, БГД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Л.Цэрэгбаяр болон бусад зочид төлөөлөгчид оролцлоо. Түүнчлэн энэхүү арга хэмжээний үеэр байлдагч нарыг ар гэртэй нь видео хэлбэрээр уулзуулсны зэрэгцээ шинэ жилийн арга хэмжээг ч



шууд дамжуулж иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн юм. БГД-ын зочид

салаа, хугацаат цэргийн алба хаагчид, БГД-ийн урлаг соёлын ажилтнуудтай хамтран урлагийн тоглолт толилуулав.

## МОНГОЛ ЦЭРЭГ-ЭНХИЙН ҮЙЛСЭД 20 ЖИЛ

Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн түүхт ойг энэ онд тэмдэглэн өнгөрүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн захирамж гарч олон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

Тухайлбал, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн түүхт ойн таних тэмдэг, зурагт хуудас, богино хэмжээний видео бичлэг шалгаруулах уралдааны эхний хэсгийг удирдамжийн дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, гадаадад үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчид, төрийн цэргийн байгууллагуудын дунд 2 үе шаттай зохион байгуулж, "Шилдэг таних тэмдэг"-ийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдээс 3 бүтээлийг шалгарууллаа. Нэгдүгээр байрт ЗХЖШ, АУГ-ын ЭДАХ болон Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн ахлах дэслэгч Б.Захчин нарын хамтын бүтээл, хоёрдугаар байрт Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн ахлах дэслэгч Б.Майдарсүрэн, гуравдугаар байрт Хилийн цэргийн 0146 дугаар ангийн 0328 дугаар тусгай салбарын дэслэгч М.Амгаланбаатар нарын бүтээл шалгарсан ажээ.

Уг удирдамжийн дагуу "Шилдэг зурагт самбар" шалгаруулах уралдаан үргэлжилж байгаа бөгөөд бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцож, бүтээлүүд ирүүлсээр байна. Уралдааны бүтээлийг хүлээн авах хугацаа энэ сарын 20-ны өдрөөр дуусгавар болох юм. Уралдаанд тавигдах шаардлага:

- Энхийг сахиулах ажиллагааны түүх, үйл ажиллагааны онцлог, уламжлал шинэчлэлийн утга санааг бэлгэдсэн, онцлох үйл явдлыг харуулсан байх;
  - Монгол бичгийн эвхмэл болон бичмэл хэлбэртэй байж болох;
  - Сурталчилгааны самбар, сонин сэтгүүл, ил захидал, зурагт хуудас, давуун материал дээр хэвлэгдэх боломжтой байх зэрэг болно.
- Цаашид ойн арга хэмжээний хүрээнд олон арга



хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд тэдгээрээс товч дурдвал:

- "Шилдэг богино хэмжээний видео бичлэг" шалгаруулах уралдаан 2022 оны II сард;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах эмэгтэй энхийг сахиулагчдын чуулга уулзалт, хүндэтгэлийн арга хэмжээ;
- "Тусгай тасар"

реалити шоу нэвтрүүлэг 2022 оны IV сард;

- "Энхийг сахиулагчдын өдөр"-ийг 2022 оны V сарын 29-нд тэмдэглэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах "Олон улсын эмэгтэй энхийг сахиулагчдын хурал" 2022 оны VI сард зохион байгуулагдах юм.

**ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэс**

## АНГИЙН АХЛАГЧИЙН БҮРЭЛДЭХҮҮН 10 КМ-ИЙН ЯВГАН МАРШААР ...



**Зэвсэгт хүчний 340 дүгээр анги**

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу ахлагч нарын бэлэн байдлыг хангах зорилгоор тактик жагсаалын хичээлийн

төлөвлөгөөг үндэслэн энэ сарын 6-ны өдөр 10 км-ийн явган маршийг ахлагчийн бүрэлдэхүүнд сахилга зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгууллаа. Маршийг ангийн ахлагч, тэргүүн ахлагч Г.Гантулга

удирдан явуулсан бөгөөд энэ үеэр байр зүй, хими, инженерийн сургалтуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган зохион байгуулсан юм.

**Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН**